



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот

□ Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай □

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гүйцэтгэх захирлын 2016 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 58 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан "Монсек ҮЦК" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2016 оны 3 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Тус үнэт цаасны компанийн ирүүлсэн саналыг харгалзан гишүүнчлэлийн хөлсийн нийт өр барагдуулах хугацааг 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр тогтоож, үүргээ хугацаандаа биелүүлээгүй тохиолдолд Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг хязгаарлах арга хэмжээ шууд авахыг "Монсек ҮЦК" ХХК /М.Отгонбаатар/-д анхааруулсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.БОЛОР

000040